



## НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 114

Улаанбаатар хот

### Ашиг орлогын хуваарилалт тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 зүйл, 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын 2021 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас нийслэлийн төсөвт 2022 онд төвлөрүүлэх ногдол ашгийн хувь, хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Төсөвт төвлөрүүлэхээр тооцсон нийт 359,664,150.0 (гурван зуун тавин есөн сая зургаан зуун жаран дөрвөн мянга нэг зуун тавь) төгрөгийн ногдол ашгийг 2022 онд багтаан нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА

Ж.БАТБАЯСГАЛАН



1110100397

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 114  
дүгээр тогтоолын хавсралт



ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРУУДААС  
НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ НОГДОЛ АШГИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

/мянган төгрөг/

№	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын нэрс	2021 он			Ногдол ашиг төвлөрүүлэх хувь	Ногдол ашгийн дүн	Хуваарилагдах ногдол ашгийн орлогын албан татвар	Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх дүн
		Орлого	Зардал	Гүйцэтгэл				
1	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар	3,794,782.99	3,276,734.27	518,048.72	50%	259,024.36	25,902.44	233,121.92
2	Хот төлөвлөлт, судалгааны институт	3,018,696.92	2,750,617.96	268,078.96	50%	134,039.48	13,403.95	120,635.53
3	Улаанбаатар зам засвар, арчлалтын газар	13,968,202.99	13,955,077.01	13,125.98	50%	6,562.99	656.30	5,906.69
	<b>Нийт дүн</b>	<b>20,781,682.90</b>	<b>19,982,429.24</b>	<b>799,253.66</b>	<b>50%</b>	<b>399,626.83</b>	<b>39,962.68</b>	<b>359,664.15</b>